Маягт -4

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙГ 2023 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 06 дугаар сарын 05 — Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвий (Гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | |
| .1.8 | НЗДҮАХ-5.1.2 | Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана. | - | УБЗАА, Дүүргүүд ХСХГ, | Дүүргийн төсөв | - | 488 | 506 | - | - | Иргэдийн амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх хүрээнд Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны 02-13-04/023/03 дугаартай “Стандартын шаардлага хангахгүй эрсдэлтэй хүүхдийн тоглоомын талбайд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж батлуулан дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:<br>- Тус газрын улсын ахлах байцаагчид нийслэлийн хэмжээнд нийт 398 хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалт зохион байгуулж, 976 хүүхдийн тоглоомын талбайн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн судалгааг гаргасан.<br>- Стандартын шаардлагад нийцээгүй болон эрсдэл үүсэх магадлалтай хүүхдийн тоглоомын талбайтай сууц өмчлөгчдийн холбоонд UCS1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ерөнхий шаардлага" хотын стандартыг мөрдүүлэх талаар улсын /ахлах/ байцаагчийн 15 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав. Нийслэлийн хэмжээнд баригдсан 14 тоглоомын талбайн тохижилтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд "UCS1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага"-ыг хангуулахаар захиалагч болон гүйцэтгэгч компанид холбогдох зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 4.2.5 | НЗДҮАХ-5.2.1 | Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Агаарын чанарын стандарт"-ыг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлнэ. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 50.0 | - | 1 | - | - | 2022 онд агаарын чанарын стандартын суурь судалгаа хийгдсэн бөгөөд "Агаарын чанарын стандарт"-ыг шинэчлэн боловсруулах ажлын даалгаварын төсөл боловсруулах, мэргэжлийн байгууллагуудаас санал авах зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. | 30 |
| 4.3.14 | НЗДҮАХ-5.3.4 | Ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тодорхойлж, хил хязгаарын дагуу стандарт хангасан хашаа барьж, эрүүл ахуйн бүсийг хамгаална. | - | УСУГ, ХСХГ НХОГ | Байгууллагын төсөв | 1,098.4 | - | 6.2 | - | - | Ундны усны эрүүл ахуйн хил хязгаарын дагуу стандарт, шаардлагад нийцсэн хашааг төлөвлөх талаар энэхүү ажлын үндсэн хариуцагч болох Ус сувгийн удирдах газарт санал, зөвлөмж өгч чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж байна. Одоогоор энэ ажилд шаардлагатай хөрөнгө батлагдаагүй тул энэ арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна. | 30 |
| 4.3.21 | НЗДҮАХ-5.3.6 | "Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн | - | ХСХГ, УБЗАА | Нийс | - | - | 2 | - | - | "Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, хөв цөөрөм, биосвайл үүсгэх, ус | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамгаалалтад тавигдах шаардлага", "Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага" баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | | | | | | | | | дахин ашиглах тухай" хотын стандартын 2 төслийг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулсан. 2023 оны 3, 4 дүгээр улиралд холбогдох мэргэжлийн байгууллагууд болон иргэд, олон нийтээс санал авч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 4.3.22 | НЗДҮАХ-5.3.6 | Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | - | - | 1 | - | - | "Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн хүртээмжийн судалгаа"-г хийсэн. Судалгааны дүгнэлт, санал зөвлөмжийн дагуу ногоон байгууламжийн эрхзүйн орчинд дараах зарчмыг тусгах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:<br>- "Орон сууцны хорооллын ногоон байгууламжийн хэмжээний доод хязгаарыг тогтоохдоо авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбайгаас тусад нь буюу зөвхөн ногоон байгууламжийн эзлэх хувийг заасан шаардлагыг тусгах";<br>- "Орон сууцны ногоон байгууламжийн хэмжээг тооцохдоо тухайн орон сууцны эзэмшил нийт талбайд харьцуулж тооцохгүй, ногоон байгууламжийг оршин суугчдад ноогдох хэмжээг тодорхойлох байдлаар тооцдог байх;<br>Дээрх зөвлөмжийн дагуу хотын стандартын төсөл боловсруулах ажлыг 2023 оны 2 дугаар хагас жилд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн дээрх санал зөвлөмжид үндэслэн "Хот суурин газрын ногоон байгууламжийн тухай хууль"-ийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар НЗДТГ-т 2023 оны | 50 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/416 дугаар албан бичгээр санал хүргүүлэв. | |
| 4.3.23 | НЗДҮАХ-5.3.6 | Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага баримт бичгийг батлуулж, хэрэгжилтийг хангуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | - | - | 1 | - | - | “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартын төслийг боловсруулсан. 2023 оны 3,4 дүгээр улиралд холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд, олон нийтээс санал авч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна. | 50 |
| 4.3.24 | НЗДҮАХ-5.3.6 | Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, мөрдүүлнэ. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 250.0 | - | 1 | - | - | “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн гарын авлага” хотын стандартын төслийг боловсруулсан. 2023 оны 3,4 дүгээр улиралд холбогдох мэргэжлийн байгууллагууд, иргэд, олон нийтээс санал авч, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна. | 50 |
| 5.1.22 | НЗДҮАХ-6.1.4 | Хотын стандартыг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмын төсөл боловсруулж батлуулан мөрдүүлж эхлүүлнэ. | - | ХСХГ | - | | - | 100 | - | - | Хотын стандарт боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулан нутгийн захиргааны 12 байгууллагаас санал авч тусгав. Журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу олон нийтээс санал авахаар “Хууль зүйн үндэсний хүрээлэн”-д хүргүүлсэн. Тус яамнаас гадагшаа чиглэсэн үйл ажиллагааг зохицуулаагүй гэсэн дүгнэлт гарсан тул 2023 оын II улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.24 | НЗДҮАХ-6.1.7 | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд орон сууцны барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. | - | ХБХГ, ХСХГ | Төр, хувийн хэвшлийн түншлэл | - | - | 19864 | - | - | Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулахтай холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас тайлангийн хугацаанд Нийслэлийн 5 дүүргээс ирүүлсэн нийт 25 өргөдөл гомдлын дагуу хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын хүрээнд хууль, тогтоомж, норм ба дүрэм зөрчсөн 1 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлж, 2 аж ахуйн нэгжид торгуулийн арга хэмжээ авсан. Дээрх өргөдөл, гомдлуудын дийлэнх нь Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хорооны 7 дугаар нэгж хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой байна. Энэ нь барилгын зөвшөөрөл олгохдоо хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг мөрдөөгүй, хүн амын нягтаршил, нийгмийн хүртээмжийг тооцоогүй, цогц төлөвлөлт хийхгүй байгаатай холбоотой байв.<br>- Мөн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийт 957 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж дүгнэлтийг баталгаажуулж ажилласан. | 50 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.27 | НЗДҮАХ-6.1.5 | Нийслэлийн авто зам, тээврийн салбарт мөрдүүлэх хотын стандартыг боловсруулж батлуулна. | - | ХСХГ | Нийслэлийн төсөв | 300.0 | - | 3 | - | - | Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Нийслэлийн авто зам, замын байгууламжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, хотын авто замын тэмдэг тэмдэглэгээ, замын байгууламжийн чанарыг боловсронгуй болгох, цаашдын чиг хандлагыг оновчтой тодорхойлох зорилгоор Авто зам, замын байгууламжийн салбарт мөрдүүлэх хотын стандартын төслийн ажлын даалгавар боловсруулсан.<br>Мөн нийслэлийн авто зам, тээврийн талаар хийгдсэн судалгаа мэдээллийг нэгтгэн цуглуулсан. Үүнд:<br>- Зам тээвэр, логистикийн хөгжил, байршлын төлөвлөлтийн судалгаа<br>- Улаанбаатар хотын зам тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх суурь судалгаа,<br>- Монгол Улсын тээвэр, логистикийн салбарын хөгжлийн тухай судалгаа<br>- Монгол Улсад ухаалаг логистик тээврийг хөгжүүлэх стратеги, судалгааг судалж дүн шинжилгээ хийв. | 70 |
| Дундаж биелэлт | | | | | | | | | | | 50% |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ,
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ДААРИЙМАА

9022090260 8314551